



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 8 дугаар сарын 09-  
ний өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 225

#### ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-10.6-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “**Орчны эрүүл мэнд**” үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэгт даалгасугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг салбар, орон нутгийн түвшинд зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг эрхэлсэн салбар болон харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэгт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Ж.ЭРДЭНЭБАТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

А.ЦОГЦЭЦЭГ

## “ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг.Нийтлэг үндэслэл

Орчны эрүүл мэнд нь дэлхий дахинаа нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болсоор байна. Тиймээс Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2015 онд баталсан Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд нийт хүн амыг эрүүл орчинд сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авахыг улс орнуудад зөвлөж байна.

Жил бүр дэлхий дахинд бүртгэгдсэн нийт нас баралтын 4 тохиолдол бүрийн 1 нь хүрээлэн байгаа орчны бохирдол болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой өвчний улмаас нас барсан байна[1].

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хийсэн тооцооллоор дэлхийн хэмжээнд 1.1 тэрбум хүн найдвартай усан хангамжгүй, 2.4 тэрбум хүн эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжгүй байна. Иймд хүн амын усан хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулахыг улс орнуудын Засгийн газарт зөвлөсөн байна. Түүнчлэн ДЭМБ-аас ариун цэврийн байгууламжид 1 ам.долларын хөрөнгө оруулалт хийхэд эрүүл мэндэд зарцуулах зардлыг 5.5-8 ам.доллараар хэмнэж, хүн амын дундах суулгалт өвчнийг 26 хувь, нас баралтыг 65 хувиар тус тус бууруулах боломжтойг тогтоожээ.

Сүүлийн жилүүдэд манай оронд хотжилт, бүтээн байгуулалт, үйлдвэржилт, техник, технологийн дэвшилтэд суурилсан нийгэм, эдийн засгийн байдал сайжирч байгаа хэдий ч нөгөө талаас түүнийг дагасан шилжилт хөдөлгөөн, орчны бохирдол ихэсч, улмаар хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдсээр байна.

Улаанбаатар хотын агаар дахь тоосонцрын (PM 2.5) агууламжийн жилийн дундаж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Агаарын чанарын зөвлөмжид заасан хэмжээнээс 20 дахин их байгаа нь 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын өвчний шалтгаант нас баралтыг 33 хувиар, насанд хүрэгчдийн уушгины архаг бөглөрөлийн шалтгаант нас баралтыг 19 хувиар, зүрхний шигдээсийн шалтгаант нас баралтыг 27 хувиар, уушгины хавдрын шалтгаант нас баралтыг 24 хувиар тус тус нэмэгдүүлж байгааг судалгаагаар тогтоосон байна[2].

НҮБ-ын Хүүхдийн сан болон ДЭМБ-аас хамтран 2015 онд хийсэн үнэлгээгээр хотын хүн амын 66 хувь, хөдөөгийн хүн амын 59 хувь нь баталгаат ундны усаар, хотын хүн амын 66 хувь, хөдөөгийн хүн амын 43 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан байна.

Улаанбаатар хотын хөрсний бохирдолтын төлөв байдалд хийсэн үнэлгээгээр үнэлгээнд хамруулсан хөрсний дээжийн 88 хувьд нь нян, хөгц, мөөгөнцөр илэрч, хөрсний бохирдлын зэргээр “их бохирдолтой” түвшинд хүрсэн байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж **хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулахаар,**

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүн амд өвчнөөс сэргийлэх мэдлэг олгож, дадал, хандлага төлөвшүүлж нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж, үйлчилгээг эрс сайжруулахаар тус тус заасан бөгөөд эдгээр зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг боловсруулав.

## **Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа**

2.1.Хүрээлэн байгаа орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг бууруулах замаар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах нөхцөлийг сайжруулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2.Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

Зорилт 1.агаарын чанарыг сайжруулж, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах;

Зорилт 2.ундны усны чанар, аюулгүй байдлыг хангаж, хөрсний бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах;

Зорилт 3.орчны эрүүл мэндийн тандалт, судалгааны чанарыг сайжруулах;

Зорилт 4.уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлийн үед хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх;

Зорилт 5.эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох;

Зорилт 6.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах;

Зорилт 7.хүний эрүүл мэндэд химийн бодисын үзүүлэх нөлөөллийг тандан судлах.

2.3.Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

## **Гурав.Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.1.Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1.агаарын чанарыг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр:

3.1.1.1.агаарын бохирдлын төлбөрийн орлогын тодорхой хувийг нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах эрх зүйн орчин бүрдүүлэх;

3.1.1.2.агаарын чанарын стандартад нийцүүлэн агаарын чанарын индексийг шинэчлэн боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих.

3.1.2.агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тандан судлах чиглэлээр:

3.1.2.1.улирлын чанартай амьсгалын замын цочмог халдварт өвчин дэгдэх үед эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

3.1.2.2.агаарын бохирдол ихтэй бүс нутагт агаарын бохирдлоос үүдэлтэй өвчин эмгэг, тухайлбал, харшил, уушгины багтраа, уушгины хорт хавдар, жирэмсний хүндрэл зэрэгт

нарийвчилсан судалгаа хийх, судалгааны дүнг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг хангах;

3.1.2.3.агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд болон эрүүл мэндийн салбарт учруулж байгаа санхүүгийн дарамт, эдийн засгийн хохирлын тооцоог үндэсний түвшинд хийх;

3.1.2.4.ажлын онцлогоос хамаарч гадаа байнга ажилладаг замын цагдаа, хот тохижилтын үйлчилгээний ажилтан, шатахуун түгээх станцын түгээгч зэрэг ажилтны дунд агаарын бохирдлын өртөлтийн үнэлгээ хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

3.1.2.5.Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа хэсгийн халаалттай өрхийн эрүүл мэндийн төвийн халаалтыг шинэчлэх асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх;

3.1.2.6.агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх;

3.1.2.7.агаарын чанарт эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээг үндэсний түвшинд тогтмол хийж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах.

3.1.3.агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр:

3.1.3.1.агаарын бохирдол ихтэй бүс нутгийн 1 хүртэлх насны хүүхдийг пневмококкийн эсрэг дархлаажуулалтад хамруулах;

3.1.3.2.агаарын бохирдол ихтэй бүс нутгийн эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг дархлаажуулалтад хамруулах;

3.1.3.3.гэр, орон байрны доторх агаарыг бохирдуулах эх үүсвэр, түүнээс хүний эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлийг тодорхойлж, нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.

3.1.4.агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар хүн амын дунд мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх, олон нийтийн санаачилгыг дэмжих чиглэлээр:

3.1.4.1.агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хийх сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, агаарын бохирдлыг бууруулахад иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын санал, санаачлагыг дэмжих;

3.1.4.2.гэр хорооллын бүсэд байрлуулах Агаарын чанарын ухаалаг хяналтын системийн тоог нэмэгдүүлэх;

3.1.4.3.агаарын бохирдлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх.

3.2.Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1.ундны усны чанар, аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр:

3.2.1.1.ундны усны үндэсний стандартыг шинэчлэн боловсруулж батлуулах;

3.2.1.2.ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх заавар боловсруулах, үндэсний хэмжээнд үнэлгээ хийх, үнэлгээ хийх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3.2.1.3.жижиг суурин газарт ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар боловсруулах, зааврын хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.1.4.хүн амын суурьшлын бүсийн хөрсний эрүүл ахуйн стандартыг шинээр боловсруулж батлуулах.

3.2.2.ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх чиглэлээр

3.2.2.1.ус хангамжийн байгууллагад усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.2.2.2.жижиг суурин газарт усны аюулгүй байдлын төлөвлөгөөг тухайн орон нутгийн онцлог, хүн амын тоо, ус хангамжийг харгалзан зааврын дагуу боловсруулж хэрэгжүүлэх;

3.2.2.3.ундны усны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилтэд олон улсын аргачлалаар үнэлгээ хийх чадвар бүхий аудиторыг бэлтгэх;

3.2.2.4.ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийг үндэсний түвшинд үнэлэх, үнэлгээний дүнг олон нийтэд нээлттэй мэдээлэх, сурталчлах;

3.2.2.5.эрүүл мэнд, байгаль орчны асуудал эрхэлсэн сайд нарын хамтарсан тушаалаар байгуулсан “Ус, ариун цэврийн байгууламжийн ажлын хэсэг”-ийн уулзалтыг улирал бүр зохион байгуулах, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах.

3.2.3.хүн амын ундны усны стандарт, ундны усны эх үүсвэрийн бүсийн дэглэм болон эрүүл мэнд, боловсролын байгууллагын ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийх чиглэлээр:

3.2.3.1.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад ундны ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг үнэлэх хяналтын хуудас нэвтрүүлэх, үнэлгээ хийх;

3.2.3.2.үндэсний түвшинд ДЭМБ-ын аргачлалын дагуу хүн амын ундны ус, ариун цэврийн байгууламжийн үнэлгээг 2 жил тутамд хийх;

3.2.3.3.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

3.2.3.4.хөдөөгийн хүн амын ундны усны чанар, аюулгүй байдалд эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээг хийх;

3.2.3.5.ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтэд эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээ хийх;

3.2.3.6.ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшинд хяналт, үнэлгээ хийх;

3.2.3.7.хот, суурин газрын суурьшлын бүс орчмын хөрсний бохирдлын байдалд үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох.

3.2.4.хүн амд ундны усны чанар болон сайжруулсан ариун цэврийн байгууламжийн талаар мэдээлэл, сурталчилгаа хийх, олон нийтийн санаачилгыг дэмжих чиглэлээр:

3.2.4.1.хүн амд ундны усны чанар, аюулгүй байдал болон сайжруулсан ариун цэврийн байгууламжийн талаар мэдлэг, ойлголт бий болгох, эрүүл амьдрах хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, энэ асуудлаар иргэд олон нийт, төрийн бус байгууллагын санал, санаачилгыг дэмжих;

3.2.4.2.нийтийн бие засах газрын тоог нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

3.2.4.3.зориулалтын бус газарт бие засахгүй байх талаар хүн амд зориулсан санамж, гарын авлага, сурталчилгааны материал боловсруулж, олон нийтийн хүртээл болгох;

3.2.4.4.хөрсний бохирдолтоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах, хөрсний эрүүл ахуйн үзүүлэлтийг сайжруулах зорилгоор нүхэн жорлон, угаадасны нүхний стандартыг мөрдүүлэх, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

3.3.Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1.орчны эрүүл мэндийн тандалт, судалгаа хийх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр:

3.3.1.1.орчны эрүүл мэндийн тандалт, судалгаа хийх, салбар хооронд мэдээлэл солилцох эрх зүйн орчинг бүрдүүлэх, орчны эрүүл мэндийн талаарх мэдээ, мэдээллийг цуглуулж, үндэсний хэмжээнд нэгтгэн шийдвэр гаргагч болон холбогдох байгууллагад эргэн мэдээлэх, мэдээллийн сан үүсгэх, мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулах;

3.3.1.2.хот, суурин газрын дуу, шуугиан, цахилгаан соронзон орон, цацраг идэвхт бодисын түвшинд тандалт, судалгаа хийж, хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх;

3.3.1.3.орчны эрүүл мэндийн болон эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний чиглэлээр хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, тархвар судлаач нарыг тандалт, судалгааны чиглэлээр мэргэшүүлэх;

3.3.1.4.орчны эрүүл мэндийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх, хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах;

3.3.1.5.орчны эрүүл мэндийн асуудлаар гадаад орнуудтай хамтын ажиллагаа өргөжүүлэх, форум, бүсийн семинар, зөвлөлгөөн зохион байгуулах.

3.3.2.эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх чадавхыг үндэсний түвшинд бэхжүүлэх чиглэлээр:

3.3.2.1.эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх журам, аргачлал боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;

3.3.2.2.эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх шинжээч, сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулан шинжээч, үндэсний сургагч багш нарыг бэлтгэх, гарын авлага боловсруулах;

3.3.2.3.эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийсэн тайлан, зөвлөмжийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх.

3.3.3.орчны эрүүл мэндийн тандалт, судалгааны лабораторийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр:

3.3.3.1.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн лабораторийн биомониторингийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах;

3.3.3.2. 5 аймгийн нийгмийн эрүүл мэндийн төвд тандалт, судалгаа хийх лаборатори шинээр байгуулж шаардлагатай тоног, төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг сургах.

3.4.Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1.хүн амын дунд уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар мэдлэг, ойлголт бий болгох, хүн амд эрүүл мэндээ хамгаалах дадал, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр:

3.4.1.1.“Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах боломж” зөвлөлгөөн зохион байгуулж, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч нарыг оролцуулах;

3.4.1.2.уур амьсгалын өөрчлөлтөөс эрүүл мэндээ хамгаалах дадал, хандлагыг хүн амд төлөвшүүлэх талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, гарын авлага боловсруулж түгээх;

3.4.1.3.уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнд дасан зохицох мэдлэг, арга хэрэгсэл, техник, технологийн талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх.

3.4.2.уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлах чиглэлээр:

3.4.2.1.Монгол орны газар зүйн байршил болон уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавраас хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлан тогтоох, олон нийтэд мэдээлэх;

3.4.2.2.уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүн амд үзүүлэх нөлөөллийн талаарх хүн амын мэдлэг, хандлагад судалгаа хийх;

3.4.2.3.анагаахын шинжлэх ухааны судлаач, эрдэм шинжилгээний ажилтнуудыг уур амьсгалын өөрчлөлтийн судалгааны арга зүйн чиглэлээр мэргэшүүлэх;

3.4.2.4.Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймагт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй зоонозын өвчний тархалтыг судлах, хүн амын өртөх эрсдэлийг тогтоох.

3.4.3.уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх чиглэлээр:

3.4.3.1.уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлээс хамгаалах талаар хүн амд зориулсан зөвлөмж боловсруулах, сургагч багш бэлтгэх ажлыг зохион байгуулах;

3.4.3.2.эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нарт зориулан уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах талаар зайн сургалт зохион байгуулах;

3.4.3.3.уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах зорилгоор “ЭКО эрүүл мэндийн байгууллага” аяныг аймаг, сум, дүүргийн түвшинд өрнүүлэх;

3.4.3.4.дамжуулагчаар дамжих халдварын эрсдэлийг бууруулах талаар хүн амд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

3.4.3.5.уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах талаар үндэсний чадавхыг бэхжүүлэх сургалтыг жил бүр зохион байгуулах.

3.5.Хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.5.1.эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

3.5.1.1.эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн талаарх журам, зааврыг шинэчлэн боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.5.1.2.эмнэлгийн аюултай хог хаягдлыг цуглуулах уут, савны стандартыг шинээр боловсруулж, аюулгүй хайрцагны стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах.

3.5.2.эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй болгон боловсруулах байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр

3.5.2.1.Улаанбаатар хотын эмнэлгийн хог хаягдлын төв байгууламжийг засварлаж, зарим тоног төхөөрөмжийг шинэчлэх;

3.5.2.2. 8 аймагт эмнэлгийн хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөө багатай аргаар устгах, боловсруулах байгууламж барьж ашиглалтад оруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.

3.5.3.эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын анхан шатны бүртгэл, мэдээллийг сайжруулж, нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээллийг шийдвэр гаргахад ашиглах чиглэлээр:

3.5.3.1.эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын мэдээллийг авах анхан шатны бүртгэл, маягтыг боловсронгуй болгох, мэдээллийн давтамж, урсгалыг тодорхой болгох;

3.5.3.2.эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын мэдээлэл цуглуулах талаар холбогдох ажилтнуудын дунд сургалт зохион байгуулах.

3.5.4.эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн чиглэлээр хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх чиглэлээр:

3.5.4.1.анагаахын боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сургуулийн төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт эмнэлгийн хог хаягдлын менежментийн асуудлыг тусгасан байдалд үнэлгээ хийх;

3.5.4.2.эмнэлгийн хог хаягдлын менежментийн талаар эрүүл мэндийн байгууллагын холбогдох ажилтнуудад зориулан ажлын байрны сургалт тогтмол зохион байгуулах;



3.5.4.3.эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эмнэлгийн хог хаягдлын менежментийн чиглэлээр гадаадад туршлага судлах сургалтад үе шаттайгаар хамруулах;

3.5.4.4.эмнэлгийн хог хаягдлын менежментийн талаарх гарын авлага, сурталчилгааны материалыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр олон нийтэд түгээх.

3.6.Хөтөлбөрийн 6 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.6.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр:

3.6.1.1.эрүүл мэндийн бүх шатны байгууллагад эрхэлж байгаа ажил, үйлчилгээ болон ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийх;

3.6.1.2.ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах журмыг шинэчлэн боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.6.1.3.хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах төлөвлөгөөг эрүүл мэндийн бүх шатны байгууллагад боловсруулан хэрэгжүүлэх, хэрэгжилтийг 2 жил тутамд үнэлэх.

3.6.2.мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгох чиглэлээр:

3.6.2.1.мэргэжлээс шалтгаалсан өвчнийг мэдээлэх анхан шатны бүртгэл, мэдээллийг “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл”-д тусгах.

3.6.3.бичил уурхай эрхлэгчид болон тэдний гэр бүлийнхний эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, мэргэжлээс шалтгаалсан өвчинд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар чиглэлээр:

3.6.3.1.бичил уурхай бүхий аймаг, сумын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжлээс шалтгаалсан өвчин, осол, гэмтэл, химийн бодисын хордлогыг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх сургалтад үе шаттайгаар хамруулах;

3.6.3.2.бичил уурхай эрхлэгчдийг явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах;

3.6.3.3.бичил уурхай эрхлэгч болон тэдний гэр бүлийнхнийг мэргэжлээс шалтгаалсан өвчин, осол, гэмтэл, химийн бодисын хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах ажлыг зохион байгуулах.

3.7.Хөтөлбөрийн 7 дугаар зорилтыг хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.7.1.хорт хавдар үүсгэгч бодисын хэрэглээг бууруулах, хориглох чиглэлээр:

3.7.1.1.Монгол Улсад ахуйн болон үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар хэрэглэж байгаа бараа, бүтээгдэхүүн, химийн бодист хавдар үүсгэгч бодисыг илрүүлэх тандалт, судалгаа хийх, хавдар үүсгэгч бодис бүхий бараа, бүтээгдэхүүн, химийн бодисын хэрэглээг бууруулах, хориглох чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэх;

3.7.1.2.хор судлалын чиглэлээр үндэсний түвшинд судалгаа, шинжилгээ хийх чадамжийг нэмэгдүүлэх;

3.7.1.3.аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлэгт хор судлалын чиглэлээр ажиллах эмч нарыг мэргэшүүлэн сургах;

3.7.1.4.ахуйн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, хүнсний зориулалтын хуванцар савны хэрэглээнд тандалт, судалгаа хийж, хүний эрүүл мэндэд хортой нь тогтоогдсон бараа, бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарлах, хориглох чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэх;

3.7.1.5.Монгол Улсад хэрэглэж байгаа асбест агуулсан бараа, бүтээгдэхүүний хэрэглээ, түүнээс шалтгаалсан өвчин, эмгэгийн тархалтыг судлах, судалгааны дүн, зөвлөмжийг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;

3.7.1.6.химийн бодисын хордлогын бүртгэл, мэдээлэл, тандалт хийх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, хэрэгжилтэд хяналт тавих.

3.7.2.ахуйн шавж, мэрэгч устгал болон ариутгал, халдваргүйтгэлийн ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр:

3.7.2.1.ахуйн шавж, мэрэгч устгал болон ариутгал, халдваргүйтгэлийн ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, ажлын байрны нөхцөлд хяналт хийх;

3.7.2.2.бага эмч, сувилагч нарыг ахуйн шавж, мэрэгч устгал болон ариутгал, халдваргүйтгэл хийх сургалтад хамруулан ариутгагч бэлтгэх.

3.7.3.ахуйн шавж, мэрэгч устгал болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисын хэрэглээ, дасан зохицолд тандалт, судалгаа хийх чиглэлээр:

3.7.3.1.ахуйн шавж, мэрэгч устгал болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисын хэрэглээ, дасан зохицлыг судалж, дүнг олон нийтэд мэдээлэх;

3.7.3.2.ахуйн шавж, мэрэгч устгал болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нэр төрөл, импортлогч байгууллага, тухайн бодисын үйлчлэл, дасан зохицол болон хүний бие махбодид үүсч байгаа гаж нөлөөг бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан байгуулах.

### **Дөрөв.Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт**

4.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

4.1.1.Хүн амын суурьшлын орчны агаар, ундны усны чанар, аюулгүй байдлын үзүүлэлт сайжирч, хөрсний бохирдолтын түвшин буурснаар эрүүл, аюулгүй орчин бүрдэж, орчны бохирдлоос үүдэлтэй хүн амын өвчлөл буурна.

4.1.2.Пневмококк болон томуу, томуу төст өвчний үүсгэгчийн эсрэг дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлснээр 5 хүртэлх насны хүүхдийн уушгины хатгалгаа, амьсгалын замын цочмог халдварт өвчний өвчлөл, нас баралт буурна.

4.1.3.Эрүүл мэндийн тандалт, нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бэхжүүлснээр хүрээлэн байгаа орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг урьдчилан тогтоож, эрсдлийг бууруулна

4.1.4.Орчны бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд бодит мэдээлэл өгснөөр хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл аж төрөх орчныг бүрдүүлэхэд ахиц гарна.

4.1.5.Салбар дундын болон төрийн бус байгууллага, иргэд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа сайжирч, үйл ажиллагааны нэгдмэл байдал хангагдана.

4.1.6.Агаарын бохирдлоос шалтгаалсан амьсгал, зүрх судасны тогтолцооны өвчлөл, хөдөлмөрийн чадвар түр алдалтыг бууруулснаар хүн амын амьдралын хугацаа уртасна.

4.1.7.Өвлийн улиралд 5 хүртэлх насны хүүхдийн дундах уушгины хатгалгаа, амьсгалын замын цочмог халдварт өвчний тохиолдол буурснаар эмнэлгийн орны ачаалал, хүлээгдэл буурч, эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлыг нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах боломжтой болно.

4.1.8.Хүүхдийн уушгины хатгалгаа, амьсгалын замын цочмог халдварт өвчний улмаас өрх гэр, гэр бүлийн гишүүдэд учрах санхүүгийн эрсдэлийг бууруулна.

4.1.9.Хүрээлэн байгаа орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан хүний эрүүл мэнд, улс орны эдийн засагт учирч байгаа хор хохирлыг бууруулах чиглэлээр салбар дундын хамтын ажиллагаа өргөжиж, харилцан уялдаа бүхий үйл ажиллагааны нэгдмэл байдал хангагдана.

4.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөө, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2016 оны мэдээллийг суурь үзүүлэлт болгон ашиглана:

Хөтөлбөрийн зорилго, зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжи х нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин, он		Мэдээллийн эх сурвалж
				2018	2020	
<b>Үр нөлөөний шалгуур үзүүлэлт</b>						
Зорилго: Хүрээлэн байгаа орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг бууруулах замаар хүнийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах нөхцөлийг сайжруулна.	Амьсгалын замын цочмог халдварт өвчлөлийн түвшин	10 000 хүн амд	981.2	962.8	944.4	Эрүүл мэндийн хөгжлийн төв
	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт	10 000 хүн амд	17.4	17.2	17.0	
	5 хүртэлх насны хүүхдийн уушгины хатгалгаа өвчний өвчлөлийн түвшин	10 000 хүн амд	2029.4	1681.4	1333.4	
<b>Үр дүнгийн шалгуур үзүүлэлт</b>						

Зорилт 1. Агаарын чанарыг сайжруулж, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах	Нэг хүртэлх насны хүүхдийг пневмококкийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан хувь	Хувь	80	85	90	Халдварт өвчин судлалын үндэсний төв
	Эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан хувь	Хувь	10	20	40	
	Агаарын чанарын ухаалаг системийн тоо	Тоо	10	12	15	Цаг уур, орчны шинжилгээний газар
	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хүн амд хийгдсэн мэдээлэл сургалт, сурталчилгааны компаниг ажил, аяны тоо	Тоо	3	8	15	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
Зорилт 2. Ундны усны чанар, аюулгүй байдлыг хангаж, хөрсний бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах	Ундны усан дахь гэдэсний савханцрын тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээжийн хувь	Хувь	10.4	9.5	9.0	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
	Ундны усан дахь нянгийн ерөнхий тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээжийн хувь	Хувь	16.8	13.0	10.0	
	Хөрсөнд дэх гэдэсний савханцарын тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээжийн хувь	Хувь	52	50	48	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
	Хөрсөн дэх Перфрингенсийн тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээжийн хувь	Хувь	54	52	50	
Зорилт 3. Орчны эрүүл мэндийн тандалт, судалгааны чанарыг сайжруулах	Тандалт судалгааны чиглэлээр сургалтад хамрагдсан хүний тоо	Тоо	-	Жилд 50-аас доошгүй мэргэжилтэн	Жилд 60-аас доошгүй мэргэжилтэн	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
Зорилт 4.	Уур амьсгалын өөрчлөлтийн	Тоо	150	200	250	Нийгмийн эрүүл мэндийн

Уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд учирч болох аюул эрсдэлийн үед хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх	нөлөөллийг сааруулах, эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээний чиглэлээр ухуулга, нөлөөлөл хийх сургагч бэлтгэх сургалтад хамрагдсан хүний тоо						үндэсний төв
	Уур амьсгалын өөрчлөлтийн судалгааны арга зүй эзэм-шүүлэх сургалтад хамрагдсан судлаач, эрдэм шинжилгээний ажилтны тоо		Тоо	30	60	90	
	Уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох чиглэлээр хийгдсэн судалгааны тоо		Тоо		2	5	
Зорилт 5. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох	Эрүүл ахуйн шаардлага хангасан эмнэлгийн хог хаягдал устгах нэгдсэн байгууламжийг шинээр барьж, ашиглалтад оруулсан хот, аймгийн тоо	Хот	Тоо	1	1	3	Эрүүл мэндийн яам
	Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн эмнэлгийн хог хаягдал түр хадгалах байртай аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвийн тоо	Аймаг	Тоо		3	8	
	Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн эмнэлгийн хог хаягдал түр хадгалах байртай аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвийн тоо	АНЭ	Тоо	3	8	21	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн эмнэлгийн хог хаягдал түр хадгалах байртай аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвийн тоо	СЭМТ	Тоо	50	100	250		
Зорилт 6.	Эрхэлж байгаа	Хувь	-		Нэгдсэн	Төрөлжсөн	Нийгмийн

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах	ажил үйлчилгээ, ажлын байрны эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь			эмнэлэг Бүсийн оношилгоо, эмчилгээний төв 100 хувь	мэргэш-лийн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, сум өрхийн эрүүл мэндийн төв 100 хувь	эрүүл мэндийн үндэсний төв, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбоо, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо
	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын хувь	Хувь	-	70	100	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбоо
	Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамрагдсан бичил уурхайчны тоо	Тоо	800	3300	5800	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв
Зорилт 7.  Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг тандан судлах	Хор судлалын чиглэлээр шинжилгээ хийж байгаа лабораторийн тоо	Тоо	-	3	8	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Хордлогын яаралтай

						тусламжийн үндэсний төв
	Хор судлалын чиглэлээр эмч бэлтгэн сургасан нэгдсэн эмнэлгийн эзлэх хувь	Тоо	30	50	100	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
	Хяналтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Тоо	Жилдээ 5-аас доошгүй байгууллага	Жилдээ 8-аас доошгүй байгууллага	Жилдээ 10-аас доошгүй байгууллага	ЭМЯ, Халдварт өвчин судлалын үндэсний төв, мэргэжлийн нийгэмлэг холбоо, мэргэжлийн салбар зөвлөл
	Шинээр бэлтгэсэн ариутгагчын тоо	Тоо		10	50	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль

## **Тав.Хөтөлбөрийн санхүүжилт**

5.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1.улс, орон нутгийн төсөв;

5.1.2.олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;

5.1.3.төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив;

5.1.4.хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

## **Зургаа.Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

6.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран жил бүр хийнэ.

6.2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг дараа оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

6.3.Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг бүх шатны Засаг дарга жил бүр хийнэ. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор хүргүүлнэ.

## **Долоо.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

7.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нийгэм, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

7.2.Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт тавих, удирдан зохицуулах ажлыг бүх шатны Засаг дарга хариуцан зохион байгуулна.